



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 06 сарын 12 өдөр

Дугаар А/285

Чингис хот

Эмийн эргэлтийн сангийн
үйл ажиллагааг зохицуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.2-ын "г", 30 дугаар зүйлийн 30.1.1, Эрүүл мэндийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.4, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Эмийн эргэлтийн санг сумын Эрүүл мэндийн төвд шилжүүлсэн тухай аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Тэргүүлэгчдийн Хуралдааны 2018 оны 54 дүгээр тогтоол нь Хэнтий аймаг дахь захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2019 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 127/ШЗ2019/0043 дугаартай захирамжаар түдгэлзүүлсэн тул Эмийн эргэлтийн сангийн үйл ажиллагааг хэвийн явуулах боломжийг бүрдүүлж, ажиллах нөхцөлөөр хангахыг сумын Засаг дарга, тосгодын Захирагч болон Орон нутгийн өмчийн газрын дарга /Ц.Дэмбэрэлсайхан/-д даалгасугай.

2. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Тэргүүлэгчдийн Хуралдааны 2018 оны 54 дүгээр тогтоолтой холбоотой захиргааны хэрэг эцэслэн шийдвэрлэх хүртэлх хугацаанд өмчийг /байр, тоног төхөөрөмж, тавилга, програм хангамж бусад үндсэн хөрөнгө/ зээлийн барьцаанд тавих, шилжүүлэх, худалдан борлуулахгүй байх баталгаа гаргуулан, Эмийн эргэлтийн сангийн бие даасан үйл ажиллагааг нь ханган ажиллахыг Баян-Адарга, Баян-Овоо, Батноров, Батширээт, Баянмөнх, Биндэр, Бор-Өндөр, Бэрх, Дархан, Дэлгэрхаан, Жаргалтхаан, Өмнөдэлгэр, Норовлин, Цэнхэрмандал сумдын Засаг дарга, Гурванбаян, Хэрлэнбаян-Улаан тосгоны Захирагч дарга нарт үүрэг болгосугай.

3. Дээрх хугацаанд иргэдийг хөнгөлөлттэй эмээр тасралтгүй хангах боломжийг бүрдүүлж, Эрүүл мэндийн төвийн нэмэлт санхүүжилтийн дансаар дамжиж байгаа хөнгөлөлттэй эмийн санхүүжилтийг Эмийн эргэлтийн сангийн дансанд цаг тухайд нь шилжүүлж ажиллахыг Баян-Адарга, Баян-Овоо, Батноров, Батширээт, Биндэр, Бор-Өндөр, Дархан, Дэлгэрхаан, Жаргалтхаан, Өмнөдэлгэр, Цэнхэрмандал сум, тосгоны сумын Эрүүл мэндийн төвийн эрхлэгч нарт үүрэг болгосугай.

2.

4. Захирамжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга /Г.Лхагвахатан/-д, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Г.Хэрлэнчулуун/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА